

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ НЭГДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2018 оны нэгдүгээр сарын 04-ний 14 цаг 10 минутад эхэлж, 15 цаг 45 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 1 цаг 35 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарын 2018 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн ХЭГ/09 тоот албан бичгээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3, Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 87 дугаар тогтооор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 1.2 дахь заалтыг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>"Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх, нэр дэвшүүлэх тухай" Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 113</p>

		дугаар тогтоолын 1 дэх заалтын "...Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох.." гэснийг хасах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
2	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарын 2018 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн ХЭГ/09 тоот албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
3	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарын 2018 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн ХЭГ/09 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**

